ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН
ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

# E-NEWSLETTER

*ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР*

***2018 оны 3-р сарын дугаар***



"ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ" УТҮГ

## -Мэдээ, мэдээлэл-

***Зам, тээвэр хөгжлийн сайдын хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг "Төмөр замын тээврийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал төслийг ГТХЗНТ-УТҮГ-ын албан хаагчдад танилцуулж, санал солилцлоо***



Төмөр замын тээврийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд "Төмөр замын тээврийн тухайхууль"-ийгшинэчлэн найруулах шаардлагатай гэсэн дүгнэлт (зөвлөмж), Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн 2017 оны "Төмөр замын тээврийн эрх зүйн орчин, хөгжлийн асуудлууд" сэдэвт эрдэм шинжилгээний хурлаас төмөр замын тээврийн эрх зүйн орчинг сайжруулах зөвлөмж гаргасан.

Монгол улсын эдийн засаг, нийгмийн тогвортой хөгжлийг дэмжсэн, олон улсын тэргүүлэх түвшинд хүрсэн, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг аюулгүй, чанартай, хүртээмжтэй үйлчилгээгээр хангасан, үр ашигтай тогтолцоог бэхжүүлэх зарчмыг баримтлан төмөр замын обьектыг барих, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг уг хуулиар зохицуулахаар хуулийн төслийн боловсруулна гэж заасны дагуу "ГТХЗНТ" УТҮГ-аас 2018 оны 2 сарын 26-нд "Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал төсөл"-д саналууд хүргүүлсэн. Зам, Тээвэр Хөгжлийн сайдын хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг 3-р сард "ГТХЗНТ" УТҮГ-ын албан хаагчидтай уулзаж "Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал төсөл"-д байгууллагын эрх зүйн статусыг тусгах, чиг үүргийг хуульчлан тодорхойлох, төмөр замын тээврийн хөгжлийн бодлого, тулгамдаж буй асуудлуудын талаар харилцан мэдээлэл солилцож, санал хүргүүлэх тухай хэлэлцлээ.

Төмөр замын салбарын шинэтгэлийн хүрээнд эрдэм шинжилгээний судалгаа, туршилт хийх, хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, норм нормативын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах, тэдгээрийг мөрдөж хэрэгжүүлэхэд хөрөнгийн эх үүсвэр шаардагддаг тул уг асуудлыг хуульчлан зохицуулах зэрэг шаардлагууд төслийг боловсруулах үндэслэл болж байна.

## -Мэдээ, мэдээлэл-

### *Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмыг боловсруулах ажлын хэсэгт ГТХЗНТ-УТҮГ-ын мэргэжилтнүүд хамрагдан ажиллаж байна*




Төмөр замын тээврийн салбарт мөрдөгдөж буй дүрэм, журмыг Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулахаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.01.24-ний 13 дугаар тушаалын дагуу:

1. Төмөр замын дохиолол холбооны журам;
2. Галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журам;
3. Төмөр замын тээвэр дэх осол, гологдлыг судлан бүртгэх журам;
4. Төмөр замаар ачаа тээвэрлэх журам;
5. Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам;
6. Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны сахилгын тусгай журам, ажлын цагийн хуваарь, хөдөлмөрийн нөхцөл;
7. Суурь бүтэц, нийтийн болон дагнасан хэрэглээний зам ашиглах, суурь бүтэц эзэмшигч,тээвэрлэгч хоорондын хамтран ажиллах болон тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлэх гэрээний үлгэрчилсэн загвар;
8. Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмуудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ГТХЗНТ-ийн 8 мэргэжилтэн хамрагдан ажиллаж байна.

Мөн "УБТЗ" ХНН-ийн албадын дарга, удирдах албан тушаалтан болон журамд хамтран ажиллах хүмүүстэй уулзан саналыг хүлээн авч боловсруулсан бөгөөд ЗТХЯ-нд ажлын хэсэг гурван удаа хуралдаж мэдээллүүдийг илүү боловсронгуй болгож хөтлөх, танилцуулах, мэдээлэл солилцох талаар тухай бүрийн саналыг нэгтгэн хэлэлцэж удирдлагуудад танилцуулан ажиллалаа.

ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

# E-NEWSLETTER

*ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САМБАР*

***2018 оны 3-р сарын дугаар***

## -Мэдээ, мэдээлэл-

### *Статистик мэдээллийг нэгтгэх, боловсруулах, төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангаж ажиллаж байна*

ЗТХЯ-ны ТЗ-ын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг шинэчлэн батлуулах ажлын хэсэгт томилогдсоны дагуу "УБТЗ" ХНН-ийн албадын дарга, удирдах албан тушаалтан болон журамд хамтран ажиллах хүмүүстэй уулзан саналыг хүлээн авч боловсруулан ажиллалаа. Мөн ЗТХЯ-нд ажлын хэсгийн хуралдаануудаар мэдээллүүдийг илүү боловсронгуй болгож хөтлөх, танилцуулах, мэдээлэл солилцох талаар тухай бүрийн саналыг нэгтгэн хэлэлцсэн юм. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн шуурхай хуралдаанаас төмөр замын байгууллагуудын хоногийн ажлын тайлан мэдээг нэгтгэн боловсруулж танилцуулах үүрэг даалгавар өгсөнтэй холбогдуулан Ачилт буулгалтын хоногийн мэдээ, Галт тэрэг, вагон солилцооны хоногийн мэдээ, Ачааны паркийн хоногийн мэдээ, Нүүрс хангалт, нөөцлөлтийн мэдээнүүдийг "УБТЗ" ХНН, "МТЗ" ТӨХК-ын цахим хаягт хандах эрхээр орж, сарын мэдээг цахимаар авч мэдээллийг боловсруулж, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

### *Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төслийн хүрээнд төмөр замын салбарт хэрэгжүүлэх төслийн саналыг боловсрууллаа.*

"ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ"-ИЙН
ТЭЗҮ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙН САНАЛ

2018.03.20

| | | |
|---|---|---|
| 1 | Зорилго | Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв байгуулах төслийг дараах үе шатны дагуу хэрэгжүүлнэ:<br><br>**а. Төвийн ТЭЗҮ-ийг эцэслэн боловсруулах:** Тэргүүлэх хөгжилтэй улс орнуудын туршлагад үндэслэсэн "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв"-ийн үйл ажиллагааны хамрах хүрээ, чиг үүрэг нийцүүлэн төмөр замын сүлжээний дагуух дохиоллын систем, тоног төхөөрөмж, техник технологийн шийдэл, технологийн барилга, байгууламжийн хийц, түүнд тавигдах шаардлагуудыг нарийвчлан судална. |
| 2 | Төсөл хэрэгжих байршил, хамрах хүрээ | Монгол Улс, Улаанбаатар хот.<br><br>ЗТХЯ-ны харьяа "Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ-ын Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах |
| 3 | Төслийн үндэслэл: /шийдвэрийн баримт бичиг/ | - Өнөөгийн байдлаар Монгол-Оросын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэг, "Монголын төмөр зам" ТӨХК, "Болдтөмөр Ерөө гол" ХХК гэсэн суурь бүтэц эзэмшигч нар үйл ажиллагаа явуулж байна.<br>- УИХ-ын 2010.06.24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ыг баталж, төмөр замын нэгдсэн сүлжээг өргөжүүлэх, томоохон уул уурхайн ордуудыг ашиглах, бүтээгдэхүүн экспортлох зорилгоор ойролцоогоор 5600 гаруй км төмөр замын сүлжээг хэд хэдэн үе шаттайгаар барьж байгуулахаар шийдвэрлэсэн.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ач тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх" зорилтыг дэвшүүлж "Тавантолгой-Гашуун сухайт", "Хөөт-Бичигт" чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулах, "Тавантолгой-Гашуун сухайт" чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, "Шивээ хүрэн-Сэхэ" чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгах, "Зүүнбаян-Ханги", "Эрдэнэт-Овоот" чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх зэрэг үндэсний томоохон бүтээн байгуулалтын ажлууд тусгагдсан.<br>- Монгол Улсын төмөр замын сүлжээг олон улсын транзит тээврийн коридор болгож хөгжүүлэх, шинээр бий болох төмөр замуудыг бусад төмөр замын сүлжээнд холбож, үйл ажиллагааг саадгүй явуулах, улсын хэмжээнд төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний нөөцийг хамгийн үр ашигтай, оновчтой ашиглах, суурь бүтцийг тээвэрлэгч компаниудад өмчийн хэлбэр харгалзахгүйгээр ашиглуулах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зэрэг нь |

### *"Хөрөнгө оруулалтын төслийн санхүү эдийн засгийн үндэслэл"-ийг Орос хэлнээс Монгол хэл рүү орчууллаа.*

ОХУ-ЫН ШУА-ИЙН СИБИРИЙН САЛБАР

БАЙГАЛИЙН НӨӨЦ, САВ ГАЗРЫН ОЛБОРЛОЛТЫН ТУВАГИЙН ХҮРЭЭЛЭН

ХОЛБООНЫ УЛСЫН ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

"ҮЛЭГ-ХЭМИЙН ЧУЛУУН НҮҮРСНИЙ САВ ГАЗРЫН ОЛБОРЛОЛТТОЙ УЯЛДУУЛАН БАЙГУУЛАХ КЫЗЫЛ-ӨРӨМЧИЙН ОЛОН УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГА"

ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбар байгалийн нөөц олборлолтын Тувагийн хүрээлэнгийн Захирал д.г.м.н. Лебедев В.И.

КЫЗЫЛ 2014

Гүйцэтгэгчдийн жагсаалт

Дабиев Д.Ф. - к.э.н., зав. лаборатории региональной экономики ТувИКОПР СО РАН

Лебедев В.И. - д.г.-м.н. директор ТувИКОПР СО РАН

## Суурь бүтцийн 2018 оны 3-р сарын тасалдлын тайлан мэдээ

Зурмагийн тасалдал:
2018 оны 3-р сард нийт 80 тасалдал, 90,3 галт тэрэг цагийн барилт үүсэж, 10,14 сая төгрөгийн хохирол гарсан байна. Өмнөх сарын тасалдлын тоо, галт тэрэгний цагийн барилт, хохирлын хэмжээтэй харьцуулахад:




График №3




График №4




Зурмагийн тасалдлын хэмжээ өмнөх сараас 37-н нэгж буюу 31,6%, 62,8-н цаг буюу 41%-иар, хохирлын хэмжээ 3,42 сая төгрөг буюу 25,22%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зурмагийн тасалдлын тоо болон тасалдлаас үүссэн хохирлын шалтгааныг үзэхэд:



## -Мэдээ, мэдээлэл-

### *Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль улсын хэмжээнд зохион байгуулагдлаа*

Энэхүү дадлага сургууль нь газар хөдлөлтийн гамшгийн аюул тулгарсан үед төрийн болон төрийн бус байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн бэлэн байдлыг хангуулах, нийслэл хотод суурилуулсан төвлөрсөн зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдал үйлчлэх хүрээг шалгах, иргэдийг гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор ажиллуулж сургах ач холбогдолтой. Дадлага сургуулийн зарлан мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжиж буй “Газар хөдлөлтийн гамшгаас амжиж анхааруулах систем байгуулах” төслийн хүрээнд Нийслэлийн 6 дүүрэгт шинээр суурилуулсан орчин үеийн зарлан мэдээлэх дуут дохиоллын цамхагаар дамжуулан ажилласан юм. “ГТХЗНТ” УТҮГ-ын албан хаагчид гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуульд идэвхтэй оролцлоо.





### *Оросын холбооны улсын төмөр замын стандартуудыг орчууллаа*

- “ГОСТ 33435-2015 Хөдлөх бүрэлдэхүүний аюулгүй ажиллагаа, хяналт, удирдлагын тоног төхөөрөмж. Аюулгүй ажиллагааны шаардлага ба хяналтын арга”
- “О+Р 941 - “Мэдээллийн сан болон мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийн аюулгүй байдал”
- “ГОСТ Р 54115-2010 - Глобал навигацийн хиймэл дагуулын систем. Нийтийн хэрэглээний төмөр замын хүлээн авагч. Техникийн шаардлага” гэсэн стандартуудыг Орос хэлнээс Монгол хэл рүү мэргэжлийн үг хэллэгт оруулан орчууллаа.

2018 оны 3-р сарын дугаар

## *"Авлигын эсрэг Нэгдсэн Үндэсний Байгууллагын конвенц" сэдэвт сургалт, мэдээллийн арга хэмжээг зохион байгууллаа*

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 т оот тогтоолоор баталсан Авилгалын эсрэг НҮБ-ын Конвенцийг Монгол Улс 2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр НҮБ-ын Авлигын эсрэг Конвенцийг соёрхон баталсан. 2003 оны 12 дугаар сарын 09-ний өдөр хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн юм. Уг конвенц нь удиртгал, 8 бүлэг, 69 зүйлтэй. 2018 оны байдлаар 143 улс нэгдэн орсон байдаг. Энэхүү конвенц нь:

1. Үр ашигтай, үр дүнтэй аргаар авилгалаас урьдчилан сэргийлэх, тэмцэх аргыг дэмжих, бэхжүүлэх
2. Олон улсын хамтын ажиллагаа, техникийн туслалцааг хөгжүүлэх, хөнгөвчлөх, дэмжих
3. Төрийн шударга, хариуцлагатай удирдлагыг бий болгох зорилготой.




## *"Жендер" сэдэвт ажлын байран дахь сургалт зохион байгуулагдлаа*

Хүнийг үндэс, угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн мэдлэг болон жендэрт суурилсан хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд албан хаагчдад зөв ойлголт, эерэг хандлагыг төлөвшүүлэх, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд нэгдсэн мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах нь чухал үүрэгтэй юм.

## *"Стрессээ удирдах нь" сэдэвт сургалт, мэдээллийн арга хэмжээнд хамрагдлаа*

Стрессгүй ажлын орчинд ажилчид хамгийн дээд хэмжээний бүтээмжтэй болж тэр хэмжээгээрээ ч ажлын үр дүн илүү өндөр байх хандлагатай байдаг. Ямар ч нөхцөл байдалд стрессээ удирдаж зохицуулж сурах нь ажлын бүтээмжийг дээшлүүлдэг байна. Уг сургалтаар стресс үүсгэх хүчин зүйлс болон тэдгээрээс хэрхэн өөрсдийгөө хамгаалах талаар мэдээлэл хүргэсэн юм.






## -Мэдээ, мэдээлэл-

### *Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлийг татаж авах боломжтой*

Төвийн цахим хуудсанд Railway illustrated, The railway magazine, Modern railways, Rail Express, Model Railway сэтгүүлийн нийт 8 дугаарыг харах болон татаж авах форматад хөрвүүлэн төвийн www.rtcc.mrtd.gov.mn цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэлээ.




